



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/640

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 "в", Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1.Ховд аймгийн Дуут сумын модон гүүрийн барилгын ажлыг байнгын ашиглалтанд оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Баярсүх -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Энхбаяр - Дуут сумын Засаг дарга
И.Гантогтох – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч

Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын авто замын хяналтын улсын байцаагч

Э.Хишигтөмөр – Дуут сумын Хөх бэлчир багийн Засаг дарга

Л.Алтанцэцэг – Дуут сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Э.Амарбаясгалан – Байгаль орчны газрын мэргэжилтэн

Б.Түмэнжаргал– Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн

Zax A/640 Ch

02 2859

Нарийн бичгийн дарга: Ц.Сувдаа – Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2.Ховд аймгийн Дуут сумын модон гүүрийн барилгын ажлыг ажлын даалгавар, зураг төсвийн дагуу, хуулийн хүрээнд байнгын ашиглалтанд авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/ -д даалгасугай.

3.Дээрх ажлын захиалагчийн хяналтын зардлаас комиссын гишүүдийн шатахуун, унаа, хоол, томилолтын зардлыг санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ